



ТӨРИЙН ӨМЧИЙН БОДЛОГО,  
ЗОХИЦУУЛАЛТЫН ГАЗРЫН  
ТОГТООЛ

2021 оны 08 сарын 12 өдөр

Дугаар 343

Улаанбаатар хот

Удирдамж болгох тухай

Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 11 дүгээр зүйлийн 6, 21 дүгээр зүйлийн 6 дахь хэсэг, Хөдөлмөрийн тухай хуулийн 39 дүгээр зүйлийн 39.1 дэх заалт, Засгийн газрын 2016 оны 80 дугаар тогтоолоор батлагдсан “Төрийн өмчийн оролцоотой хуулийн этгээдэд төрийн өмчийн төлөөллийг хэрэгжүүлэх журам”-ын 3.1.3 дахь заалтыг тус тус үндэслэн ТОГТООХ нь:

1. “Монголын төмөр зам” төрийн өмчит хувьцаат компанийн Төлөөлөн удирдах зөвлөлд төрийн өмчийн төлөөлөл хэрэгжүүлж буй гишүүдэд дараах арга хэмжээ авч хэрэгжүүлэхийг удирдамж болгосугай:

1.1. “Монголын төмөр зам” төрийн өмчит хувьцаат компанийн гүйцэтгэх захирал Рэнцэнханд овогтой Батсүхийг өөрийнх нь хүсэлтийн дагуу үүрэгт ажлаас нь чөлөөлж, түүнтэй байгуулсан контрактыг холбогдох хууль тогтоомжийн дагуу цуцлах асуудлыг шийдвэрлэх.

1.2. Р.Батсүхийг “Монголын төмөр зам” төрийн өмчит хувьцаат компанийн Ерөнхий инженерийн албан тушаалд томилох.

2. Энэхүү тогтоолын биелэлтэд хяналт тавьж ажиллахыг Төрийн өмчийн удирдлага, зохицуулалтын хэлтэс (Ц.Баяр-Эрдэнэ)-т даалгасугай.

ДАРГА

Б.ЦЭНГЭЛ

ТӨРИЙН ӨМЧИЙН УДИРДЛАГА,  
ЗОХИЦУУЛАЛТЫН ХЭЛТСИЙН  
ДАРГА

Ц.БАЯР-ЭРДЭНЭ

• 132001280